

*Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барьж байгуулах, үйлдвэрлэх, тоног төхөөрөмж угсарч суурилуулах, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах комиссын ажиллах журамын нэгдүгээр хавсралт*

**Түлш, Эрчим хүчний яам**  
**Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв**

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДӨЛ**

**САНАМЖ**

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барьж байгуулах, үйлдвэрлэх, тоног төхөөрөмж угсарч суурилуулах, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд “Сэргээгдэх эрчим хүчний тухай”, “Эрчим хүчний тухай” хуулиуд, Түлш, Эрчим хүчний сайдын .....тушаалыг үндэслэн Эрчим хүчний зохицуулах газар, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл өмчийн хэлбэр харгалзахгүй тусгай зөвшөөрөл олгоно. Зохих шаардлагын дагуу бүрдүүлсэн тусгай зөвшөөрөл олгох материалыг хүлээн авсан өдрөөс 21 хоногт багтаан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг газар дээр нь шалган, шалгуур үзүүлэлтийг хангасан болох нь тогтоогдвол тусгай зөвшөөрөл олгох комиссын хурлаар хэлэлцэж эцсийн шийдвэр гаргана. Аймаг орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгжүүд тухайн аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн тодорхойлолтыг бичиг баримтад хавсаргана.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага, аж ахуйн нэгжүүд Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвтэй гэрээ байгуулж, түүнийг жил бүр дүгнэж, хавсралт маягтын дагуу тайлан ирүүлнэ.

Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас хуанлийн 30-аас доошгүй хоногийн өмнө тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад бүрдүүлэх баримт бичгийг шаардлагын дагуу бүрдүүлж ирүүлэх бөгөөд тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үр дүнгээр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах эсэх асуудлыг комиссын хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Хэрэв дурьдсан хугацааг ажлын 15 хоногоос илүү хугацаагаар хожимдуулсан тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцно.

Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс ..... төгрөгийг Төв төрийн сан дахь Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвийн ....., нормчлолын сангийн шимтгэлийг... ..тоот дансанд тус тус шилжүүлж, төлбөрийн даалгаврын нэг хувийг авчирч өгнө.

Тусгай зөвшөөрөл шинээр олгоход бүрдүүлэх баримт бичгийг зохих маягтуудаар компьютер буюу бичгийн машинаар алдаа, засваргүй, цэвэр нямбай, үнэн зөв бүрдүүлсэн байна.

Тусгай зөвшөөрөлд сунгалт хийлгэхэд зохих маягтуудаар компьютер буюу бичгийн машинаар цэвэр нямбай, үнэн зөв бичихийн зэрэгцээ дараах материалыг нэмж бүрдүүлнэ.

**Үүнд:**

1. 2-3 захиалагчийн тодорхойлолт
2. Тусгай зөвшөөрөл авах чиглэлийн дагуу 2-3 объект ашиглалтанд оруулсан комиссын актын хуулбар
3. Фото зураг /тайлбартай/
4. Урьд жилүүдэд тушаасан нормчлолын сангийн шимтгэл төлсөн баримтын хуулбар
5. Харъяалах татварын албаны тодорхойлолт

зэрэг болно.

Жич: Хөдөө, орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгж нь тухайн аймаг дахь эрчим хүчний улсын байцаагчийн дүгнэлт гаргуулж хавсаргана.

Өргөдлийн загвар

**Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвд**

Тусгай зөвшөөрөл хүсэх тухай

Манай байгууллага / нэгж/ дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулахад тусгай зөвшөөрөл авах, /сунгах, сэргээх / хүсэлтээ илэрхийлж байна

Үйл ажиллагааны төрөл, ажил үйлчилгээний жагсаалт  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлсэн бичиг баримт нь үнэн зөв бөглөгдсөн бөгөөд шаардлагатай тохиолдолд ажлын талбай болон тоног төхөөрөмж, машин механизмыг үзүүлэхэд бэлэн болно.

Манай байгууллага /аж ахуйн нэгж/ тусгай зөвшөөрөл авсан ажил, үйлчилгээгээ хэрэглэгчийн ашиг сонирхолыг хангасан бөгөөд технологийн дагуу холбогдох хууль тогтоомж, норм дүрмийг мөрдөж мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэх болно. Манай байгууллага /аж ахуйн нэгж/ олгогдсон тусгай зөвшөөрөлтэй холбоотой хууль тогтоомжид заасан үүрэг, хариуцлагыг хүлээх болно.

**Байгууллагыг төлөөлж:**

Дарга / Захирал/ ..... / Овог нэр/

гарын үсэг

Тэмдэг

Ерөнхий инженер ..... / Овог нэр/

гарын үсэг

Огноо

Тусгай зөвшөөрлийн маягтыг бүрдүүлэхдээ тусгай зөвшөөрлийг хүсэж буй ажилбарын хүрээнд тавигдах шалгуур үзүүлэлтийг сонгож бичнэ үү.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТ

	Үзүүлэлт	Тайлбар
1	Оноосон нэр, өмчийн хэлбэр	
2	Улсын бүртгэлийн дугаар: Регистрийн дугаар:	
3	Аж ахуйн нэгжийн дүрмийн сан	
4	Энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлсэн хугацаа	
5	Аж ахуйн нэгжийн албан ёсны хаяг	
6	Шуудангийн хайрцаг, харилцах утас, факс, E-mail	
7	Эрхэлдэг ажлын үндсэн чиглэл	
8	Харьяалагдах татварын алба /дүүрэг/	
9	Байгуулагдсан он:	

**Тайлбар:** Заавал хавсралт болгох материал.

1. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, гадаадын хөрөнгө оруулалттай бол сертификатын хуулбарыг баталгаажуулан хавсаргана.

Дарга / Захирал/ ..... / Овог нэр/  
гарын үсэг

Т эмдэг

Маягт 12

**Байгууллагын товч танилцуулга**

/ товч танилцуулга, тусгай зөвшөөрөл авах болсон зорилго /

--

Дарга / Захирал/ ..... / Овог нэр/  
гарын үсэг

Тэмдэг

Маяг<sup>13</sup>

**Санхүүгийн мэдээлэл. /Сүүлийн гурван жилээр /**

Жил	Нийт хөрөнгө	Эргэлтийн хөрөнгө	Нийт борлуулалт
1.	2	3	4

**Удирдах болон ИТА-ын товч тодорхойлолт**

Овог нэр	Нас хүйс	Албан тушаал	Мэргэжил	Тухайн салбарт ажилласан жил	Тухайн байгууллагад	Регистр д
----------	----------	--------------	----------	------------------------------	---------------------	-----------

						ажилласан жил		
	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>8</b>	

**Мэргэжилтэй ажилчдын тодорхойлолт**

Овог нэр	Нас хүйс	Тухайн салбарт ажилласан жил	Мэргэжил	Мэргэжлийн үнэмлэхний дугаар	Мэргэжлийн зэрэг	Регис
<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>

Дарга / Захирал/ ..... / Овог нэр/ гарын үсэг

Т эмдэг

М аягт 14

**ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧИЙН СҮҮЛИЙН 2 ЖИЛД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ**

/сунгалт хийлгэх үед/

Гүйцэтгэсэн ажлын нэр /объектын нэр/	Объектын хүчин чадал	Хэрэгжүүлсэн ажлын өртөг (мян/төг)

Дарга / Захирал/ ..... / Овог нэр/

гарын үсэг

Т эмдэг

Маягт 15

**Боловсон хүчин / хүний нөөц /**

Мэргэжил	Тоо	Дундаж нас	Ажилласан дундаж жил
Удирдах албан хаагчид	Удирдах боловсон хүчин		
	Санхүү		
Инженер техникийн ажилтан	Цахилгааны инженер		
	Дулааны инженер		
	Технологийн инженер		
	Сантехникийн инженер		
	Хэмжүүр автоматикийн инженер		
	Реле хамгаалалт, тавил тооцооны инженер		
	Холбооны инженер		
	Барилгын инженер		
	Зохион бүтээгч инженер		
	Цахилгааны техникч		
	Дулааны техникч		
	Бусад		
	Хэсгийн дүн		
Үүнээс	Зөвлөх инженер		
	Мэргэшсэн инженер		
	Тэргүүлэх төсөвчин		
	Мэргэшсэн төсөвчин		
Мэргэжлийн ажилчид	Цахилгааны монтёр		
	Тоноглолын засварчин		
	Гагнуурчин		
	Токарчин		
	Кранист		
	Сантехникч		
	Оосорлогч, дохиочин		
	Өрлөгө дулаалгын засварчин		
	Мужаан		
	Бусад		
	Хэсгийн дүн		

Дарга / Захирал/ ..... / Овог нэр/




Дарга / Захирал/ ..... / Овог нэр/  
гарын үсэг

Т эмдэг

Маягт 18

### Машин, тоног төхөөрөмжийн жагсаалт

/АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХЭД ШААРДАГДАХ МАШИН МЕХАНИЗМ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ,  
АЖЛЫН БАГАЖ ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ/

	Машин механизм, тоног төхөөрөмж, ажлын багаж хэрэгслийн нэр	Тоо ширхэг	Хүчин чадал	Эдэлгээний чанар, хэдэн оноос ашиглаж байгаа	Эх үүсвэ /хувий түрээсэл
0	1	2	3	4	5
А	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм				
1					
2					
3					
Б	Технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл				
1					
2					
3					
В	Хэмжүүр ба хяналт, шалгалтын багаж хэрэгсэл				
1					
2					
3					
Г	Хөдөлмөр хамгаалаллын багаж хэрэгсэл.				
1					
2					
3					

**Тайлбар: Машин тоног төхөөрөмжийн гэрчилгээ, паспортын хуулбарын  
хавсаргана.**

Дарга / Захирал/ ..... / Овог нэр/  
гарын үсэг

Т эмдэг

*Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барьж байгуулах, үйлдвэрлэх, тоног төхөөрөмж угсарч суурилуулах, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах комиссын ажиллах журмын хоёрдугаар хавсралт*

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛӨӨР ОЛГОХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

**Нэг.** Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барьж байгуулах, үйлдвэрлэх, тоног төхөөрөмж угсарч суурилуулах, засвар үйлчилгээ эрхлэх

### **1.1. Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барьж байгуулах, тоног төхөөрөмж угсарч суурилуулах ажил**

- 1.1.1. Нар, салхины цахилгаан станц, түүний тоног төхөөрөмж, дагалдах барилгын ажил
- 1.1.2. Усан цахилгаан станц , түүний тоног төхөөрөмж, дагалдах барилгын ажил

### **2.1 Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр үйлдвэрлэх, засвар үйлчилгээ эрхлэх**

- 2.1.1. Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр үйлдвэрлэх, засвар үйлчилгээ хийх

.....oOo.....

*Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барьж байгуулах, үйлдвэрлэх, тоног төхөөрөмж угсарч суурилуулах, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах комиссын ажиллах журамын гуравдугаар хавсралт*

1.1. C□/td>

### **Тусгай зөвшөөрлийн үнэ тариф**

Тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ гаргахдаа үндсэн нэр төрлийн үнэ болох 150000 төгрөгийг Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвийн Худалдаа хөгжлийн банк дахь 499 078 092 тоот төгрөгийн дансанд тушаана уу?

Тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээний үнийн хэмжээ

1. Тусгай зөвшөөрөл олгох үндсэн нэр төрлийн үнэ 150000 төгрөг байна. Уг төлбөр эргэн төлөгдөхгүй
2. Шинээр тусгай зөвшөөрөл авах сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр үйлдвэрлэх, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд болон бусад тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээний үндсэн нэр төрлийн үнэ. /Тусгай зөвшөөрөл олгогдсоны дараа ажилбарын үнийг төлнө./

Категори код	Ажилбарууд	Хураамж /жилд/
1.1.1.	Нар, салхины цахилгаан станц, түүний тоног төхөөрөмж, дагалдах барилгын ажил	500000
1.1.2.	Усан цахилгаан станц, түүний тоног төхөөрөмж, дагалдах барилгын ажил	400000
2.1.1.	Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр үйлдвэрлэх, засвар үйлчилгээ хийх	400000

Жич: тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын чадамж, үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, дээшлүүлэх зорилготой.

**Тусгай зөвшөөрлийн гэрээний загвар**

Т ү лш, эрчим х ү чний сайдын 2007 оны

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОГЧ, ТҮҮНИЙГ ЭЗЭМШИГЧИЙН ХООРОНД  
БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР**

Огноо Дугаар

***Нэг. Ерөнхий зүйл***

1. Монгол улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 7.1, 15.8.2 дугаар зүйлд заасны дагуу олгосон тусгай зөвшөөрлийн хавсралт энэхүү гэрээг Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв /цаашид тусгай зөвшөөрөл олгогч гэх /.....аж ахуйн нэгж, байгууллага/цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх/-ын хооронд 200 . . . оны . . . дугаар сарын . . . – ний өдөр байгуулав.

2. Энэхүү гэрээ нь хоёр талын гарын үсэг зурж баталгаажуулсанаас 3 жилийн хугацаанд хүчинтэй байх бөгөөд талууд гэрээнд заасан үүргийн биелэлтийг тооцож гэрээний хугацаа дуусахаас нэг сарын өмнө хамтран дүгнэнэ.

3. Олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах, гэрээнд заасан үүрэг хариуцлага хүлээхдээ хоёр тал Монгол улсын хууль тогтоомж, түүний дотор Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль, " Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барьж байгуулах, үйлдвэрлэх, тоног төхөөрөмж угсарч суурилуулах, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам" болон энэхүү гэрээ зэрэг бусад нийтлэг дүрэм журмыг мөрдөнө.

***Хоёр. Гэрээнд оролцогч талуудын нэр, хаяг***

2.1. Тусгай зөвшөөрөл олгогч тал:

Улаанбаатар хот. Түлш, эрчим хүчний яамны харъяа Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв

2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч тал:

Хаяг: .....

егистрийн дугаар: .....

Утас .....

Факс .....

***Гурав.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа***

3.1. Үйлчилгээний хүрээ нь:

Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байна.

3.2. Дор дурьдсан ажил үйлчилгээний төрлийг эрхэлнэ.

А -----

Б -----

В -----

Г -----

3.3. Тусгай зөвшөөрөлд заасан тухайн төрлийн ажил үйлчилгээний чиглэлээр сонгон шалгаруулалтад оролцох.

#### ***Дөрөв .Тусгайзөвшөөрөлэзэмшигчийнүүрэг***

4.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхтэй холбогдсон стандарт техникийн нөхцөл, технологи, зураг төсөл, норм дүрэм, норматив техникийн бусад баримт бичгийг чанд мөрдөн чанарын шаардлагыг бүрэн хангаж, гүйцэтгэсэн ажлын чанарын баталгааг хариуцна.

4.2. Техникийн магадлал, туршилт хийлгэж баталгаажуулах шаардлагатай, өөрийн эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд хийгдэж буй ажлуудад техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм журамд заагдсаны дагуу зохих хугацаанд нь туршилт, магадлалт, баталгаажуулалт хийлгэж улсын мэргэжлийн байгууллагын байнгын хяналтад ажиллана.

4.3. Үйлдвэрлэлийн осол аваариас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулж, улсын хяналтад хамаарах объектод гарсан осол аварийн талаар Түлш, эрчим хүчний яама нд шуурхай мэдэгдэн, осол аварийн тайлан мэдээг хагас бүтэн жилээр гаргаж т усгай зөвшөөрөл олгогчид өгч байна.

4.4. Өөрсдийн аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж буй инженер техникийн ажилтан, ажилчдын / монтёр, гагнуурчин, засварчин, кранчин, машинч гэх мэт бусад/ мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургалтыг зохион байгуулж тэднийг жил бүр шалгалт, аттестатчилалд оруулж ажиллана.

4.5. Өөрийн эрхэлж буй ажил үйлчилгээний талаар хэрэглэгчийн зүгээс тавьсан санал, гомдлыг шийдвэрлэн барагдуулж байх бөгөөд энэ талаар тусгай зөвшөөрөл олгогчид жил бүр мэдээлж байна.

4.6. Эрхэлж буй ажил үйлчилгээний хүрээнд зах зээлийн шударга өрсөлдөөнд саад учруулах үйл ажиллагаа явуулахгүй.

4.7. Шинэ нэр төрлийн ажил үйлчилгээ эрхлэх бол энэ тухай хүсэлтээ тусгай зөвшөөрөл олгогчид гаргаж шийдвэрлүүлнэ.

4.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл олгоход шаардагдах холбогдох зардлыг /Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний үнэ, норм, дүрэм, гарын авлага, бичиг хэргийн зардал г.м/ т усгай зөвшөөрөл олгогчид өгнө.

#### ***Тав. Тусгай зөвшөөрөл олгогчийн үүрэг***

5.1. Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон баримт бичгийг хянах, газар дээр нь очиж танилцах, үнэлэлт дүгнэлт гаргах, тусгай зөвшөөрөл бичиж олгох, гэрээ байгуулах, хүчинтэй хугацааг тодорхойлох, олгосон тусгай зөвшөөрөл, байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг шалгах зэрэг ажлыг хэрэгжүүлнэ.

5.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын ажил үйлчилгээний чанар, норм дүрэм, стандарт, техникийн нөхцөл, технологийн мөрдөлтөд хяналт

тавина.

5.3. Тусгай зөвшөөрөлд заасан ажил үйлчилгээ эрхлэх болон энэхүү гэрээний гуравдугаар зүйлд заасан үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу баталгаажуулж эрх ашгийг нь хамгаалж ажиллана.

5.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагад гарсан томоохон аварга, хүний амь үрэгдүүлсэн, хүнд бүлэг ослыг судлахад оролцож акт дүгнэлт гарган тэдгээрийг дахин гаргуулахгүй байх арга хэмжээ авч ажиллана.

5.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрхэлж буй ажил үйлчилгээнийх нь талаар гарсан хүсэлт, санал гомдлыг тухай бүр нь хүлээн авч хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлэнэ.

5.6. Хоёр тал гэрээг хамтран дүгнээд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэнд тооцсон нөхцөлд анх олгосон тусгай зөвшөөрлийн хугацааг хүчинтэйд тооцох ба хугацаа дууссан бол уг тусгай зөвшөөрлийг журамд заасан хугацаагаар шинээр бичиж олгоно.

### ***Зургаа. Хариуцлага ,төлбөр***

6.1. Хоёр тал тухайн гэрээ болон тусгай зөвшөөрөлд заасан үүргээ биелүүлээгүй бол хууль тогтоомжийн дагуу торгууль хүлээх болон зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, үйлчилгээний төлбөрийг тодорхой хэмжээгээр хорогдуулах зэрэг хариуцлагыг харилцан хүлээнэ.

6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь "Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барьж байгуулах, үйлдвэрлэх, тоног төхөөрөмж угсарч суурилуулах , засварын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журам" ба энэхүү гэрээнд заасан ажил үйлчилгээний төлбөрт ..... төгрөгийг ..... - ны ..... банкин дахь ..... тоот дансанд ..... оны ..... сарын ..... – ний өдөр багтаан шилжүүлнэ.

6.3 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай аливаа саналыг талууд албан бичгээр харилцан солилцож шийдвэрлүүлнэ.

### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

**ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОГЧ**

.....  
/Түлш, эрчим хүчний яамны харьяа  
Сэргээгдэх эрчим хүчний үндэсний  
төвийн дарга/

**ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ**

.....  
(аж ахуйн нэгж байгууллага,  
дарга, захирлын нэр)